

“Нако түлш” ХК-ийн 2016 оны хагас жилийн үйл ажиллагааны тайлан

Компанийн нэр: ”Нако түлш” ХК

Хаяг: Дархан-Уул аймаг, Дархан сум, Үйлдвэрийн хотхон 13-р баг

Утас:70379006

Улсын бүртгэлийн дугаар:	1910001019
Регистрын дугаар:	4489969
Үйл ажиллагааны чиглэл:	Хагас коксон утаагүй түлшний үйлдвэрлэл
Хувьцаа эзэмшигчдийн тоо:	126 /2016.03.18-ны байдлаар/

Үйл ажиллагааны тайлан:

“Нако түлш” ХК 2016 оны 1-6 сард дараахи ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Нийт 3467,1 тн нүүрс хүлээн авч 2334,5 тн нүүрс боловсруулан 1697,0 тн хагас кокс боловсруулав.
- Үнс ялгагч циклон хөлдөж бөглөрсөн, агаар өгөх хоолой задарсан, хий алдагдсан, зуухны доод клапангын редуктор хагарсан зэрэг гэмтлүүдийг засаж арилгаснаар зуухны хэвийн үйл ажиллагааг хангав.
- Зуухны дээд гидроклапанд мэдрэгч суурилуулж нүүрс ачаалах операторын ажлыг хөнгөлөв.
- Улаанбаатар хот уруу 25 тн хагас кокс борлуулалтанд ачуулж, 20 орчим онныг борлуулав.
- Зуух зогсоосны дараа зуух ба технологийн шугамын цэвэрлэгээ хийв.
- Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулж 2015оны үйл ажиллагааны тайланг танилцуулав.
- 2500 тн хагас коксыг -25мм, +25мм фракцаар шигшиж хурааж дуусав.
- 2015-2016 онуудад Шарын гол ХК-аас хүлээн авсан нүүрснээс ялгасан чулууг татаж тараан 700м² талбай тэгшилэн 50%-ийг хөрсжүүлэв.
- Бүхэл нүүрсээр ажилладаг нам даралтын уурын зуух, оффис, ахуйн байрны халаалтын зуухыг нунтаг нүүрс, шатдаг хийн тэжээлтэй болгох техникийн шийдлийг гаргаж туршилт хийв.
- Өөрийн бололцоонд тулгуурлан үхрийн баас, шар шавар, цементэн барьцалдуулагчтай хагас коксон брикет хийх туршилтын ажлуудыг хийж, шинжлүүлэхээр лаборторт дээж өгөөд байна.

Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд:

Тус компани нь 2016 оны 06-р сарын 30-ны өдрөөр дуусгавар болгон санхүү байдлын тайлан, орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан тэнцлээ Олон улсын стандарт болон Монгол Улсын нягтлан бодох бүртгэлийн хууль түүнд нийцүүлэн гаргасан журам, заавар, аргачлалаар мөрдөж байгаа хууль тогтоомжийн дагуу гарган санхүү, татварын байгууллага болон холбогдох бусад газруудад тушаасан.

Компанийн 2015, 2016 оны жилийн орлогын тайлангийн үзүүлэлтээс зэрэгцүүлэн үзвэл:

Үзүүлэлт	2015 он	2016 он
Борлуулалт	2908.5	56762.3
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	1657.3	178299.9
Нийт ашиг	1251.2	-121537.5
Үйл ажиллагааны бус орлого	19.2	7.0
Үйл ажиллагааны зардал	148371.8	317753.8
Үйл ажиллагааны бус зардал	180.2	186.1
Татвар төлөхийн өмнөх ашиг/алдагдал	-147281.6	-439470.4
Орлогын татварын зардал	114.6	0
Цэвэр ашиг,алдагдал	-147396.2	-439470.4

Үйл ажиллагааны борлуулалтын орлого 2016 онд “Тэгшхан” ХХК-д 170,8 тн , Мөнхийн илч ХХК-д 135,78 тн, Таван нуур ХХК-д 190,56 тн, Бурхантын илч ХХК-д 85,88 тн, Бүрэн дулаан ХХК-д 233,43 тн, ЭМТ наран ХХК-д 140,42 тн, Улаанбаатар хотын эцсийн хэрэглэгчдэд 25 тн хагас кокс борлуулсан байна.

Цалин хөлсний зардалд 181435,3 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 45142,1 мянган төгрөг, ашиглалтын зардалд 21562,4 мянган төгрөг, түлш шатахуун, тээврийн хөлс сэлбэг хэрэгслийн зардалд 15089,7 мянган төгрөг, ХХОАТ 7000,0 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

Компанийн 2015 он, 2016 оны хөрөнгө, эх үүсвэрийн тэнцлийн үзүүлэлтээс зэрэгцүүлэн үзвэл:

Хөрөнгө өр төлбөрийн үзүүлэлтүүд	2015 он	2016 он
Эргэлтийн хөрөнгө	619666.7	1125353.7
Эргэлтийн бус хөрөнгө	2897951.7	2797420.9
Нийт хөрөнгийн дүн	3517618.4	3922774.6
Богино хугацаат өр төлбөр	1197192.8	2463069.2
Урт хугацаат өр төлбөр	797686.2	773528.1
Эзэмшигчийн өмчийн дүн	1522739.4	686177.3
Өр төлбөр,эзэмшигчийн өмчийн дүн	3517618.4	3922774.6

Ноогдол ашгийн талаарх мэдээлэл:

Компани 2015 онд алдагдалтай ажилласан тул ноогдол ашиг тараагаагүй болно.

Үнэт цаас гаргагчийн хяналтын багц эзэмшигчдийн болон ТУЗ-ийн мэдээлэл:

Компани их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгээгүй. Компанийн хяналтын багц эзэмшигчдийн хувьд өөрчлөлт ороогүй.

Компанийн хяналтын багц эзэмшигчдийн мэдээлэл

№	Овог нэр	Албан тушаал	Хувьцааны хувь
1	Шарын Гол ХК	Нүүрс олборлолт	92,93%

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр Б.Батбаатар, Жэймс Пассин, Ж.Баясгалан, Ж.Эрдэмбилэг, Д.Даянбилгүүн, Б.Лхагвадорж, хараат бус гишүүдээр Д.Нарангоо, Б.Мянганбаяр, Д.Түвшинтөгс нар ажиллаж байна.

Үнэт цаас гаргагчийн удирдлага, эрх бүхий албан тушаалтны танилцуулга:

№	Овог нэр	Албан тушаал	Эрхэлж буй ажил	Боловсрол
1	Б.Батбаатар	ТУЗ-ийн дарга, ердийн гишүүн	Шарын гол ХК-ийн гүйцэтгэх захирал	Дээд
2	Жэймс Пассин	Ердийн гишүүн	Шарын гол ХК-ийн ТУЗ-ийн гишүүн	Дээд
3	Ж.Баясгалан	Ердийн гишүүн	Нако Түлш ХК-ийн гүйцэтгэх захирал	Дээд
4	Ж.Эрдэмбилэг	Ердийн гишүүн	СВМ ХХК-ийн гүйцэтгэх захирал	Дээд
5	Д.Даянбилгүүн	Ердийн гишүүн	БиДиСек ХК-ийн гүйцэтгэх захирал	Дээд
6	Б.Лхагвадорж	Ердийн гишүүн	БиДиСек ХК-ийн тэргүүн дэд захирал	Дээд
7	Д.Нарангоо	Хараат бус гишүүн	Үнэмлэхүй эрх ХХК-ийн гүйцэтгэх захирал	Дээд
8	Б.Мянганбаяр	Хараат бус гишүүн	СВМ ХХК ажилтан	Дээд
9	Д.Түвшинтөгс	Хараат бус гишүүн	МУИС, Монгол хэл соёлын сургууль, багш	Дээд
10	Ж.Энхцэцэг	ТУЗ-ийн нарийн бичиг	Нако Түлш ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичиг	Дээд

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх захирал нар 100 хувь компанийн засаглалын сургалтанд хамрагдсан.

Компаний хувьцаа эзэмшигчдийн 2016 оны ээлжит хурлыг хуульд заасан хугацаа, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан журамд заасан шаардлагад нийцүүлэн “Нако Түлш” ХК **2016 оны 04 сарын 22**-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулж дараах асуудлыг шийдвэрлэсэн.

1. Компанийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. Компанийн аудитын хорооны тайланг хэлэлцэн батлах
3. 2016 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлах
4. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
5. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын 2016 оны зардлын төсвийг батлах
6. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах

Хурлаар хэлэлцсэн асуудлуудыг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар баталсан.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн гишүүдийг сонгосон бөгөөд 2016 оны 05 сарын 23-ны өдөр Төлөөлөн Удирдах зөвлөлийн хурлыг хуралдуулан ТУЗ-ийн дэргэдэх хороодыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсон.

А. Төлөөлөн удирдах Зөвлөлийн дэргэдэх Аудитын дэд хороог Б.Мянганбаяр, Д.Даянбилгүүн, Д.Нарангоо гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Аудитын хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус Б.Мянганбаяр гишүүнийг томилсон.

Б. Төлөөлөн удирдах Зөвлөлийн дэргэдэх Цалин урамшууллын дэд хороог Б.Лхагвадорж, Б.Мянганбаяр, Д.Түвшинтөгс гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Цалин урамшууллын дэд хорооны даргаар ТУЗ-ийн гишүүн Б.Лхагвадорж -г томилсон.

В. Төлөөлөн удирдах Зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх дэд хороог Ж.Эрдэмбилэг, Д.Түвшинтөгс, Д.Нарангоо гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Нэр дэвшүүлэх дэд хорооны даргаар ТУЗ-ийн гишүүн Ж.Эрдэмбилэгийг томилсон.

“Нако Түлш” ХК **2015 оны 04 сарын 16**-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулж дараах асуудлыг шийдвэрлэсэн.

1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. Компанийн аудитын хорооны тайланг хэлэлцэн батлах
3. 2015 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлах
4. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
5. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын 2015 оны зардлын төсвийг батлах
6. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах

“Нако Түлш” ХК **2014 оны 04 сарын 22**-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулж дараах асуудлыг шийдвэрлэсэн.

1. Компанийн 2013 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. Компанийн аудитын хорооны тайланг хэлэлцэн батлах
3. 2014 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлах
4. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
5. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын 2014 оны зардлын төсвийг батлах
6. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах